

## ХХ ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН УЛИАСТАЙ ХОТ

У.Гонгоржав

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

**Өгүүллийн товч агуулга:** Монголын хуучин хотуудын нэг Улиастай хотын нийгэм-эдийн засаг, улс төр, соёлын амьдралыг холбогдох архивын сурвалж, судалгааны зохиол, аянчин жинчингийн замын тэмдэглэлийн үндсэн дээр хотын түүх судлалын үүднээс задлан шинжилсэн буй. Үүний үр дүнд ХХ зууны эхэн үеийн Улиастай хот нь Их Хүрээний дараа орох Монгол улсын засаг захиргаа, эдийн засаг, соёлын төв хот цэрэг-стратегийн түшиц газар байсан нь мэдэгдэж байна. Энэ нь хотын эдийн засгийн амьдрал, тухайлбал худалдаа санхүү банк зээлийн үйл ажиллагаа, анхан шатны боловсруулах жижиг үйлдвэр монгол, орос бага сургууль, шуудан цахилгаан холбооны үйл ажиллагаа Улиастайд энэ үед гарсан улс төрийн тэмцэл зэргээр батлагдаж байна.

**Түлхүүр үг:** Нийт үндэстний хот, шашин мөргөлийн буюу Хүрээ хот, засаг захиргаа цэрэг худалдааны хот, Улиастай хот, ХХ зууны Монголын нийгэм-эдийн засаг, улс төрийн 2-р төв хот.

Хот, хотжилт, хотын боловсрол үүссэн тухайт асуудал хүн төрөлхтний түүхийн нийтлэг үзэгдэл агаад тэр нь хүний ахуй, соёл иргэншлээс /Нүүдэл, суурьшлаас/ үл хамааран өөрийн хөгжлийн зүй тогтолоор хөгжсөөр өнөөгийн төвшинд хүрч ирсэн нь эдүгээ нэгэнт тодорхой болжээ. Ингэхлээр монголчуудын хот, хот байгуулалтын түүхийн асуудлаар хэдийгээр манай эрдэмт ахмад түүхчид нилээд зүйл хийсэн ч гэсэн /Х.Пэрлээ Монгол улсын эрт дундат үеийн хот суурины товчоон УБ., 1961. С.Пүрэвжав, Д.Дашжамц. Хувьсгалын өмнөх Их Хүрээ УБ., 196, Д.Гонгор Ховдын хураангуй түүх УБ., 1964. М.Санждорж. Улиастай хот байгуулагдсан түүхээс Д.Майдар Монголын архитектур ба хот байгуулалт УБ., 197 гм/ дэлхийн хотуудын түүхийн судалгааны субъектийн хувьд их чамлалттай байгааг хэлэх юун.

Зохиогч энэ бяцхан өгүүлэлд монголын хуучны цөөн хотуудын нэг Улиастай хотын ХХ зууны эхэн үеийн нийгэм-эдийн засаг, улс төрийн түүх байдлыг товч өгүүлэхийг зорив.

Европын дундат зууны хотууд үүссэн түүхийг судалсан хүмүүс тэдгээр нь эртний Грек, Ромын хот, цэргийн бэхлэлтийн суурин дээр, эсвэл сүм хийдийн орчимд, нэг бол худалдааны зам харгуй, гүүр, далайн усан буудал хавьд үүссэн гэж онолын талаас нь ерөнхийлөн ангилсан байдаг. Нарийвчлан үзэхүл, монголын эрт дундат үеийн хот суурины үүсэл уг шаг ч мөн тиймэрхүү байдалтай буй. Асуудлыг чингэж ойлговол хувьсгалын өмнө Монголд 800 орчим сүм хийд байсан (Энэ тоо судалгаа, сурталчилгааны ном зохиолуудад янз бүрээр тэмдэглэсэн байдаг нь ерөнхийдөө 700-1000 дотор хэлбэлзэж байгааг бодолцож дунджаар авсан) болохоор засаг захиргаа иргэний шинжтэй цөөн хотуудаас гадна мөн тийм хэмжээний шашин мөргөлийн шинжтэй хот суурин газар байсан гэж үзэж болох мэт. Гэвч монгол хотууд Европын дундат зууны хотуудаас тухайн улсуудын эдийн засаг, нийгэм-улс төрийн амьдралд гүйцэтгэсэн үүргээс их өөр тул тэдгээрийг жичлэн судлахгүйгээр нүүдэл, суурин газруудын хотуудын нийтлэг өвөрмөцийг гаргах аргагүй байна.

Улиастай хот бол Манжийн цэргийн хуаранг түшиглэж, 1733 онд үүссэн. Монголын дундат зууны хотуудын нэг юм. Манай томоохон түүхчдийн нэг Д.Гонгор Ховд хотын түүхийг улируулан шинжилсэн нэгэн сэдэвт зохиолдоо монгол хотуудын шинж байдал, тэдгээрийн монголчуудын нийгэм, улс төрийн амьдралд гүйцэтгэж байсан үүрэг, ялгаа, онцлог зэргийн талаар сонирхолтой сэдлэг санаа дэвшүүлсэн байх нь:

"XVII –XX зууны эхэн үеийн Монголд нилээд олон хотыг гарал үүсэл, хөгжлийн хир хэмжээ, төрх байдлаар нь нийт үндэстний ба шашин шүтлэг засаг

захиргаа, цэрэг худалдааны гэх зэргээр ялган хэлэлцэж болох юм. Үндэсний ба шашны хотуудад бүх монголчуудын улс төр эдийн засгийн дэвшилтэд чухал нөлөө үзүүлж байсан Их Хүрээ, Хөх хот зэрэг орохоос гадна, Эрдэнэ зуу, Заяын шавь, Вангийн Хүрээ, Амарбаясгалант зэрэг Хүрээ хотуудыг нэрлэж болох юм. Нөгөө 2 дахь хэсэгт Ховд, Улиастай, Хиагт зэрэг хамаарагдана"<sup>1</sup>

Энэ ангиллаар үзэх ахул XX зууны эхэн үеийн Улиастай хот нь Засаг захиргаа, цэрэг, худалдааны хотод хамаарагдаж байна. Манж нар Зүүн гарын улсыг байлдан дагуулах үед Улиастай хот Монгол дахь засаг захиргаа, цэргийн гол тулгуур төв болж байсан. Гэвч XVIII зууны үеэс Жавзандамба хутагтын өргөөгөөр үүсэл нь тавигдсан Халхын Их хүрээ улам бүр өсөн төлжиж, шашин, газар зүйн байршлын давуу талаараа Ар Монголын гол хот болж, Улиастай нь засаг засаглал, худалдааны 2 дахь хот болж хувирчээ<sup>2</sup>.

XIX зууны сүүл үеийн Улиастай хот нь 100 хүрэхгүй байшин барилга гэр хорооллоос бүрдэж байсан, хотоос 2 мод /версть/ газар манж амбан, хоёр туслах /хэбэй амбан/-тайгаа суудаг Сангийн хот, өмнөт этгээдэд нь 1 мод газар хятад тариалангийн газар /60-аад он хүртэл ногоон хашаа нэртэй байв. У.Г/ байсан<sup>3</sup>. Энэ зууны эхэнд хотын хүн ам нь 3000 үүнээс орос 100, монгол 300-400 бусад нь хятад иргэд байжээ<sup>4</sup>. Хотын хүн амын олонх нь орос хятад худалдаачид гар урчууд байсан боловч монгол дархчууд, худалдаачин, хөлсний ажилчид борчууд цөөнгүй байсан ажээ. Хотын захиргаа үндсэндээ манж амбан, Улиастайн жасаа жанжны мэдэлд байсан агаад тусгайлсан хотын дарга /мэр/ гэж байсангүй.

XX зууны эхэн үеийн Улиастай хот нь юуны өмнө Ар Монголын худалдааны том төв байсаныг тэмдэглэх хэрэгтэй. 1919 оны байдлаар энд Хятадын 16, Оросын 5 пүүс байсан. И.Майскийн тооцоолсоноор худалдааны жилийн эргэлт 3,5-4 сая рубль байжээ<sup>5</sup>. Энд Хятадын худалдаа барагцаалбал хот байгуулагдсан цагаас эхэлсэн<sup>6</sup> бөгөөд 1757 онд манж нар Улиастай худалдааны хот хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн<sup>7</sup> бол Оросууд 1868 оноос Улиастайд худалдаалж эхэлжээ<sup>8</sup>. Чухам Улиастай хот бол XX зууны эхэн үед Ар Монгол, Орос, Хятадын худалдааны гол зангилаа газар болсон байжээ. Худалдааны гол замуудыг дурьдвал:

- Бельцарск /одоогийн Коцыл/ -Хангилцаг-Улиастайн 700 км зам нь Улиастай Оросын Енисей мөрний худалдааны хотуудтай холбож байв.
- Монд-Хатгал-Улиастай. 600 км
- Ховд-Улиастай-Заяын шавь-Өргөө 1550 км энэ зам нь улсын дотоодын засаг захиргаа, эдийн засгийн төвүүдийг холбосон гол зам.
- Улиастай- Сайр ус- Хаалганы 1900 км энэ зам нь Хятадтай хийх худалдааны гол зам болно.
- Улиастай-Гүчэн 900 км. Энэ зам нь гадаад Монголыг Зүүн гарын үржил шимт баян бүрдтэй холбодог Хятадтай хийх худалдааны өөр нэг зам<sup>9</sup> юм. Эдгээр жин тээврийн замууд нь үндсэндээ бүх монголын төдийгүй, олон улсын худалдаа стратегийн ач холбогдол бүхий зам байсан юм. Улиастайд Монголын бараг бүх хотуудад салбартай Даашинхүү, Тянь и дэ зэрэг томоохон хятад пүүсийн салбар байсан агаад хот, хотын орчим нийт 80 гаруй хятад пүүс, дэлгүүр байсан<sup>10</sup> ажээ. А.Позднеевийн бичсэнээр жил

<sup>1</sup> Д.Гонгор. Ховдын хураангуй түүх. УБ., 1964 х 15

<sup>2</sup> И.М.Майский. Монголия на кануне революций М.8 1960 с 166

<sup>3</sup> М.В.Певцов. Путешествия по Китаю и Монголии М., 1951 с 281

<sup>4</sup> И.М.Майский. Дурьдсан зохиол. с 102

<sup>5</sup> И.М.Майский. Мөн зохиол. с 161

<sup>6</sup> А.М.Позднеев. Города северной Монголии. Спб 1880 с 70

<sup>7</sup> М.Санждорж. Халхад Хятадын худалдаа нэвтэрч хөгжсөн нь. УБ., 1963

<sup>8</sup> И.М.Майский. Дээр дурьдсан зохиол. с 180

<sup>9</sup> И.М.Майский. Дурьдсан зохиол. с 153-154

<sup>10</sup> М.Санждорж. Халхад Хятадын худалдаа нэвтэрч хөгжсөн нь. УБ., 1963. х 82

бүр Улиастай Хөх хотын хооронд зөвхөн Даашинхүүгийн пүүс л гэхэд өөрийн 1500 тэмээгээр тогтмол жин тээлгэдэг байжээ<sup>11</sup>.

Улиастайн Орос худалдаачдын ихэнх нь Бийск, Барнаулынх байсан агаад 1910 онд Оросын 5-6 том пүүс, гадаад экспортын төлөөний хүн 3 байв. Улиастайн орос худалдааны ахлагч И.Г.Игнатъевийн жилийн гүйлгээ 333000 рубль байв<sup>12</sup>. Тус орны худалдаачид ч бас Улиастайд ирж наймаа хийдэг байв. Тухайлбал Хүрээнээс Стукен К. Яков, Зергагены пүүсийнхэн Улиастайн орчимд ирж ноос авч, Хиагтаар дамжуулан шууд Америкт гаргаж байв<sup>13</sup>. Гэсэн хэдий ч Улиастайн зах зээлд Орос, Хятадын худалдаачид зонхилж байсан билээ. Тэдгээр худалдаачид Монголоос их төлөв мал, малын бүтээгдэхүүн (мах, үхэр, адууны шир, нэхий, сарлаг адууны дэл сүүл хонь, тэмээний ноос) байгалийн гаралтай түүхий эд /ангийн арьс үс, түлш, барилгын мод, давс хужир мөөг г.м авч оронд монголчуудын ахуйн хэрэгцээт зүйлс оруулж ирдэг байжээ. Хятадаас их төлөв цай, гурил будаа, тамхи гаанс, хөөрөг, бөс даавуу, Оросоос мөн гурил будаа голлон, савхи, булигаар, төмөр, ангийн зэвсэг зэргийг оруулдаг байсныг онцлууштай. Ер нь тэр үед аль хэдийн хүчээ авсан хятад худалдаачдын гол өрсөлдөгч нь Оросын худалдаачид байжээ. Орос худалдаачид Улиастайгаас авсан мал, бусад бүтээгдэхүүнээ Хөшөө мод, Бийск, Эрхүүгийн чиглэлээр гаргаж байжээ. Дотоод жин тээврийн тухайд Нийслэл Хүрээ, Ховд, Хиагт, Сайн ноён, Засагт хан аймгийн бараг бүх хошууд Түшээт хан, Ховдын хязгаарын нилээд олон хошуу, гадаадаа Бийск, Хөшөө Цайдам, Гүчин, Жанчхүү, Хөх хот зэрэг газартай харилцаатай байжээ<sup>14</sup>. Худалдаанд дэнс мөнгө /ембүү/, Орос /гамбургийн/ цагаан мөнгө, мөнгөн төгрөг, оросын рубль, мөнгөн тэмдэгт зэргийг хэрэглэж байсан ч монголчуудын үндсэн баялаг хонь, хамгийн өргөн хэрэглээний таваар цайг аливаа өглөг авлагад нэгж болгож, түүнтэй бусад таваарыг дүйх, хэмжих зэргээр үнэлж байв. 1910 онд 1 цай 5 кг хонины ноос, эсвэл 1 шүдлэн хоньтой дүйцэж байжээ<sup>15</sup>. С.Идшинноров Улиастайн захын 1917 оны гүйлгээний архивын материалыг нэгтгэн шинжлээд гаалийн тасалбар нь олдсон 10 сарын гүйлгээний нийлбэр 134890 рубльтэй тэнцэж байгааг тэмдэглэсэн байна<sup>16</sup>.

Энд тэмдэглэвэл зохих нэгэн зүйл байгаа нь Оросын худалдаачид өрнөдийн соёлын зарим шинэ зүйлийг оруулж ирж байсны нэг нь Мөнд-Хатгал-Улиастайн 560 бээр /600 км орчим/ цахилгаан мэдээний шугам<sup>17</sup> болно. Үүнээс гадна, Оросууд асуудалд судалгаатай ултай хандаж байсанаараа монголчуудын ахуй соёлд нөлөөлөх талаараа хятадуудаас ангид байсан юм. Яг энэ үед Монголын олон газраар явж судалгаа хийсэн И.М.Майский "Автономит Монгол дахь оросуудын бүх нэр хүнд, нөлөө Орос үндэстний ямар нэгэн онцгой шинж байдалтай биш, харин оросууд бол Европын соёлыг төв Азид нэвтрүүлэх тэргүүний авангард хүч болж байгаатай холбоотой гэж бардаагаар хэлж болно"<sup>18</sup> гэж бичсэн нь үнэний хувьтай юм.

1905 оноос Улиастайд Оросын консул суух болж, Хангайн нуруунаас баруун тийшэх оросуудын асуудлыг эрхлэх болжээ.

Улиастайн эдийн засгийн түүхийн асуудал дан худалдаагаар хязгаарлагдахгүй, бас жижиг атугай ч гар үйлдвэр байсныг дурьдахгүй өнгөрч болохгүй юм. Энд орос жуулчин шинжээчдийн дурьдсанчлан гэр ахуйн зүйлс

<sup>11</sup> М.Санждорж. Мөн тэнд

<sup>12</sup> Московская тоговая экспедиция в Монголию М., 1912 с 149

<sup>13</sup> Ш.Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа. I дэвтэр. УБ., 1971. х 164

<sup>14</sup> С.Идшинноров. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-эдийн засгийн байдлын асуудал

<sup>15</sup> Д.Гонгор. Дээр дурьдсан зохиол. х 89-90

<sup>16</sup> С.Идшинноров. Дурьдсан зохиол. х 88

<sup>17</sup> И.М.Майский. Орчин үеийн Монгол. /Автономит Монгол XX зууны гараан дээр/ Орч.Отгон УБ., 2001 х. 196

<sup>18</sup> И.М.Майский. Мөн зохиол. х 119

хийдэг урчуудаас гадна, ноос угаах жижиг үйлдвэр байжээ. Нүдээр үзсэн шинжээчийн бичсэнээр бол ноос угаах үйлдвэрийн усан дотор зогсох хамгийн хүнд дамжлага дээр ажиллахад хөлсөнд нь өдөрт 1 цай /70 коп/ намар тийшээ сэрүү унаж, ус хүйтрэхэд 1 цайн дээр 4 хадаг /20-24 коп/ нэмдэг. Эмэгтэйчүүд ноос савах, ялгах, хатаах ажил хийх бөгөөд эрэгтэйчүүдээс 50% бага букуу тал цай авдаг<sup>19</sup> байжээ. Эндээс ХХ зууны эхэн үеийн Монголын хот суурин газрын хөлсний ажилчны ерөнхий дүр төрх тодорхой харагдаж байна.

Улиастайн эдийн засгийн амьдралыг харуулах өөр нэгэн баримт нь банк зээлийн асуудал билээ. Хаант Оросын Сангийн Яамны сайд бөгөөд СнЗ-ийн дарга агсан С.Ю.Виттегийн санаачилгаар 1896 онд байгуулсан Орос-Хятадын банкны салбар 1900 онд Их Хүрээ, Улиастайд нээгдэн ажиллаж байгаад 1908 онд хаагдсаныг ашиглан, Манж Чин улсын банкны салбарыг нээсэн нь мөнгө зээл, хүүгийн үйл ажиллагаа явуулж байгаад 1911 онд хаагджээ. 1915 онд Оросын оролцоотой байгуулагдсан Монголын үндэсний банкны салбар мөн Улиастайн газар ажиллаж байжээ<sup>20</sup>.

Дурьдсан баримтуудаас үзэхэд, Улиастай түүний ойр орчимын хошуу нутагт таваар-мөнгөний харилцаа нэвтэрч, мөнгөөр арилжаалах явц нэмэгдэж жижиг таваарын аж ахуй үүсч байжээ гэж үзэж болмоор байна.

Өртөө, шуудан харилцааны хувьд ч Улиастай, тухайн үедээ Монгол улсын чухал боомтын нэг байжээ. ХХ зууны эхэнд дээр дурьдсан цахилгаан мэдээний шугамаас гадна Монда-Улиастай, Өргөө-Улиастай гэсэн шуудангийн дотоод шугамаар үйлчилгээ явуулж байсан агаад хөнгөн шуудан нь сард 2 удаа, хүнд нь /илгээмж, мөнгө г.м/ сард 1 удаа үйлчилдэг байжээ. 1918 оноос англичуудын санаачилгаар хятадын шуудан Өргөө-Улиастай-Ховд гэсэн замаар 1919-1920 онуудад үйлчилж байсан<sup>21</sup> зэрэг нь төв орон нутгийн улс төр, эдийн засаг соёлын харилцааг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж байв. Улиастайд монгол бага сургуулиас гадна бас орос сургууль байсан<sup>22</sup> бөгөөд Ховд Улиастай хотуудад хятад ши янгууны жүжигчид үе үе ирж тоглодог байсан нь орос жуулчдын аяны тэмдэглэлд үлдэж хоцорчээ<sup>23</sup>.

ХХ зууны эхэн үеийн Улиастай хот нь баруун хязгаар, Сайн ноён хан, Засагт хан аймгийн засаг захиргааны гол төв байв. Улиастайн жанжны газар нь ногоон тугийн цэрэг гэдэг хэдэн зуун манж, хятад цэргээр хамгаалуулж байсан агаад монголчуудын хүч хөрөнгөөр байгуулсан 2 давхар шавар ба усан хэрмээр хүрээлэгдсэн, хэрмийн дотор бат бэх шорон гяндантай байжээ<sup>24</sup>. Чухам иймээс ч өнгөрсөн зууны эхэн үед Монголд өрнөсөн улс төрийн үйл явдлуудын гол төвүүдийн нэг нь Улиастай байсан нь санамсаргүй хэрэг биш юм. XIX зууны сүүл ХХ зууны эхэн үед Манж Чин улсын дарангуйллын эсрэг монголын ард түмний тэмцлийн нэгэн хэлбэр нь дотоодын самуунаа дарахаар Улиастайд татаж цуглуулсан монгол цэргүүдийн /1888 оны Онолт, 1900 оны Энхтайваны/ үймээн болно. 1900 оны Улиастайн цэргийн бослого нь "хотын оршин суугчдад санаа авахуулж гүн сэтгэгдэл төрүүлсэн тул манж нар эзэн хааны эрх мэдэл хязгаар оронд хэвээр бат бэх байна гэж "цаазны сум" эргүүлэх зэргээ хийж ардын сэтгэл зоригийг шантлан номхруулах гэсэн нь тус болсонгүй. Цэргийн бослого Манжийн ноёрхол доройтон унах ёр нэгэнт орсон гэдгийг ард түмэнд тодхон үзүүлжээ"<sup>25</sup>

Өгүүлэн буй үеийн Монголын нийгэм улс төрийн амьдралыг тухайн үед монголд ирж байсан олон хүмүүсийн тэмдэглэл, бүтээлүүдэд

<sup>19</sup> Московская торговая экспедиция в Монголию. М., 1912. с 181

<sup>20</sup> С.Идшинноров. Дээр дурьдсан зохиол. х 11

<sup>21</sup> И.М.Майский. Орчин үеийн Монгол. х 196

<sup>22</sup> И.М.Майский. Монголия накануне. с 94

<sup>23</sup> Мөн зохиол. с 88

<sup>24</sup> Ц.Сономдагва. Манжийн үеийн засаг захиргааны зохион байгуулалт. УБ., 1961 х 31-32

<sup>25</sup> Ш.Нацагдорж. Ар Монголд гарсан ардын хөдөлгөөн. УБ., 19 х 47

тодорхой тусгагдсан байдгийн үндсэн агуулга нь цөм нэг байна. "Хүүхдээсээ аваад үүхдээ хүртлэх бүх монголчуудын туйлын хүслэн нь хятадын дарангуйллаас чөлөөлөгдөх явдал", "Лам удирдлагатай, хятад засаглалтай монголчууд өөрийн захирагчиддаа хүлцэнгүй үйлчилсэн хэвээр байна. Гэвч аймгууд /монголчууд У.Г/ аль хэдийнээ хөдөлгөөнд оржээ. Дургүйцэл тэмцэл тусгай газар нутгуудыг хамарч байна. Монгол орон аажмаар дэлхийн тавцан дээр шинээр гарч ирэх нь"<sup>26</sup> г.м.

1910-аад онд Баруун Монголд амьдарч асан А.В.Бурдуков Тагна Урианхай баяд хошууны ардууд Тэсийн голд суурьшиж байсан хятадууд руу дайрч мал барааг нь булааж, өрийн дансыг нь галдан шатааж байв. Ховд Улиастайн баруун этгээдэд ч ийм самуун дэгдэж байв гэж тэмдэглэсэн байдаг<sup>27</sup>. 1911 оны эцсээр Манж Чин улсын ноёрхлыг түлхэн унагааж, Их Хүрээнээс манж амбаныг хөөн Түр засгийн газрыг байгуулаад байсан донсолгоонт үед Манжийн засаг захиргаа нь дотоод зохион байгуулалтын хувьд монгол журган, цэрэг, сан, дотоод журган гэх 4 хэлтэс, монгол олон аймгийн хэргийг эрхлэх 4 жасаанаас бүрдэж байсан агаад ерөнхийд нь Дайчин улсын хааны төлөөний сайд манж жанжин /тэр цагт Кузфэн гэгч хүн байж/ ерөнхийлөн удирдахын дээр бас монгол зөвлөх сайд /дайчин ван Гүргэмжав байж/ хамтран хэрэг шийтгэлцдэг байлаа. Тэд монголын ард түмний үндэсний хувьсгалын ололт, тэрхүү хөдөлгөөний өрнөлтийг хүлээн зөвшөөрөхгүй байснаар үл барам тэрхүү хөдөлгөөнийг таслан зогсоохыг горилон, хуучин хятад цэргийн дээр тус хотын энгийн хятад иргэдээс мянга шахам хүн элсэн авч цэрэг болгон зэвсэг хувцас цалин амуу зүйлийг олгон ... өдөр бүр сурган боловсруулж ... их бага үхэр буу жагсаан тавьж, сэргийлэн бэлтгэж байв<sup>28</sup>.

Ийм нөхцөлд Түр засгийн газар 1911 оны өвлийн тэргүүн сарын 22-нд "Засагт хан, Сайн ноён хан аймгийн цэргийг өөр өөрийн нь жанжны газар цуглуулж, Их Хүрээнээс илгээх ноёд түшмэдийн хамт нийлж, Улиастайн манж хятадын түшмэдийг хөөн зайлуулах"<sup>29</sup> шийд гаргасан нь тус орныг харийн дарлалаас бүрмөсөн чөлөөлөх, тусгаар улсын дотоод байдлыг илбэн тохинуулж, бэхжүүлэхэд чиглэсэн чухал арга хэмжээ болсон байна. Энэхүү шийдвэрийг хүлээн авсан Засагт хан нар "харъяат аймгаас 400 цэрэг дайчилж туслагч жанжны газар хуралдуулахаар олон хошууны засгуудад тушаагаад басхүү Улиастайн цагдаа цэрэг хоёр зууг тус захирах газрын түшмэдэд захиран авахуулж, Яруу голын газар бэлтгэж, олон сүр хавсарч, үлдэн хөөлгөх хэргийг хурдлан өдөр хугацаж"<sup>30</sup> байсан атал, ван Гүргэмжав нар "Манж цэргийн тоо, зэвсэг, хэрэглэл үлэмж, монгол цэргийн тоо цөөн"<sup>31</sup> хэмээн цаг алдаж, хувийг хичээж байсан нь ван Гүргэмжав манж жанжинтай журмын ах дүү болсонтой холбоотой байсан бололтой.

Гэвч Улиастай хотынхоны шахалт түр засгийн газрын шахалтаар 1911 оны XII сарын 22-нд манж жанжинд арга буюу тулган шаардах бичиг өгсөний дотор "Харъяат хотын хүү сангийн зэр зэвсэг мөнгө торго, аму будаа, олон албаны адуу, морь, тэмээний зэрэг элдэв чухал холбогдсон зүйлийг бүрнээ манай монгол хувийн сайд ванд гардан тушаан өгч, энэ оны 11 сарын шинийн 7-ны дотор өөр өөрийн амь хүчээр уг хотноо хойш зайлан одвоос зохино"<sup>32</sup> гэж дурьджээ. Нөгөөтэйгүүр Улиастайн иргэдэд хандан "энгийн олон худалдаа, аж үйлдвэрийн

<sup>26</sup> А.Н.Беннигсен. Несколько данных о современной Монголии. Сиб. 1912 с 61. Д.Каррутеев "Неведомая Монголия" Сиб. 1914 т 1. с 314

<sup>27</sup> А.В.Бурдуков. В старой и Новой Монголии. М., 1969. с 53- 55

<sup>28</sup> Ш.Нацагдоржийн хэвлэлд бэлтгэсэн "МОНГОЛ УЛСЫН АВТОНОМИТ ГЭДЭГ ӨӨРТӨӨ ЭЗЭРХЭН ЗАСАХ ЭРХТ ЗАСГИЙН ҮЕИЙН ҮНЭНХҮҮ ЯВДАЛ. ЧУХАМ БАЙДАЛ УЧРЫГ ТЭМДЭГЛЭСЭН ТОВЧ ӨГҮҮЛЭЛ" УБ., 1960.х 6

<sup>29</sup> Л Дэндэв. Монголын товч түүх. 4-р дэвтэр. УБ., 1934 х 26

<sup>30</sup> УТТА. А-3-311

<sup>31</sup> Ш.Нацагдорж. "Монгол улсын автономии ..." х 7

<sup>32</sup> УТТА. А-3-311

иргэдийг ер үлдэн хөөж, халдан зовоох явдал огт үгүй<sup>33</sup> гэх зэргээр ухуулах бичиг гаргасан нь нүдээ олсон зөв тактик байсны хувьд шинээр бэлтгэж байсан хятад цэргүүд /иргэд/-ийг зэвсгийг огоорон, амийг бодон, худалдааны хороололд шилжихэд хүргэсэний дээр “ногоон тугийн түшмэл цэрэг” ч санаа нийлжээ<sup>34</sup>

Нөхцөл байдал ийм аятайгаар эргэсэн хийгээд тулган шаардах бичгийн хугацаа ч нэгэнт дууссан тул 1911 оны XII сарын 28 нд Улиастай хотын зэвсэггүй хэдэн арван иргэд<sup>35</sup> цөөн тооны монгол цэргийн хүчинд дулдуйдсан ван Гүргэмжав нар тэргүүтэй хүмүүсийг сангийн хотноо ороход манж жанжин сайд, түшмэд ихэд сандралдан их багагүй “одоо бид албаны газраас зайлахыг үнэхээр санавч орох оронгүйг та бүхэн мэднэ. Түр нэгэн удаа худалдааны олон пүүсний иргэдэд тушааж хэд хонуулахыг<sup>36</sup> охилон гуйж байсан нь цаг хожин, Ховд, Өрөмч, Шар сүмээс ирэх хятад цэргийн туслалцааг хүлээх гэсэн башир арга байв. Ийнхүү санаачлагыг гартаа авсан монгол сайд Гүргэмжав нар дээрээс ирэх тушаал зааврыг хүлээх ялдамдаа “тэсгим хүйтний” нэрээр шалтаглан аль болох пүүсэнд өөрсдий нь юмыг хэрэглүүлэн гагцхүү орон төдийг өгч цөөн хоног суулгасугай<sup>37</sup> хэмээн худалдааны олон пүүсний захирсан иргэн Шү ү-жүд даалган, “багш хааны эрдэнийн сууринд залрах цагт багтаан зайлуулж<sup>38</sup> худалдааны хотод шилжүүлэн суулгажээ. Ийнхүү 1911 оны XII сарын 29 гэхэд Улиастай дахь манжийн засаг захиргаа монголчуудын гарт шилжжээ. Судлаачдын дунд байдаг энэ үйл явдлын он цагийн зөрүүтэй саналуудыг нэгэн мөр болгохоор зохиогч бяцхан өгүүлэл бичсэн билээ<sup>39</sup>.

1921 оны хувьсгалын гол төвүүдийн нэг нь мөн л Улиастай хот байсныг бид мэдэх билээ.

Дээр дурьдсан зүйлийг товчлон хураангуйлбал хувьсгалын өмнө Монголд байсан олон хүрээ хотуудаас гадна, засаг захиргаа, цэрэг, иргэний шинжтэй цөөн хотуудын нэг XX зууны эхэн үеийн Улиастай нь үнэхээр нийслэл Хүрээний дараа орох Монгол улсын засаг захиргаа, эдийн засаг, соёлын төв хот, улс төр, цэрэг стратегийн чухал түшиц газар болж байсны дээр, тэр цагийн монгол хотуудын амьдрал, ерөнхий төрхийг харуулж байна.

#### Abstract:

Among the numerous towns in the pre-revolutionary Mongolia, at the onset of the 20<sup>th</sup> century Uliastay was one of the few cities with a prerogative of the seat of military and civil administration. Uliastay was indeed the second largest city in Mongolia after Urga, and a large administrative, economic, cultural conglomerate, situated in a strategically important location.

<sup>33</sup> Ш.Нацагдорж “Монгол улсын автономи ...” х 9

<sup>34</sup> УТТА. А-3-311. х 10

<sup>35</sup> А.В.Бурдуков. Дээр дурьдсан зохиол. х 56

<sup>36</sup> УТТА. А-3-311. х 10

<sup>37</sup> УТТА. А-3-311 х 10

<sup>38</sup> Мөн тэнд

<sup>39</sup> У.Гонгоржав. Улиастай дахь манжийн засаг захиргааны төв устсан нь *Studia TUSELOGICA* т II. Fasc 3. УБ., 1975. х 27-31